

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **Экскаватор /3,0-3,5м³/**
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202112156**

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **“Экскаватор /3,0-3,5м³/”** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019, 2020 оны жилийн эцсийн тайлан.
- Аудитын тайлан ирүүлэх жилийн тоо: 2019, 2020 он.
- Борлуулалтын хэмжээ: 2019, 2020 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгосон үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Туршлага: 2019, 2020 онд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт, эсхүл гэрээ дүгнэсэн актын хамт. Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2 жилээс багагүй (2019, 2020).

Тендерийн хамт **57 600 000 /тавин долоон сая зургаан зуун мянга/** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 09:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:10 цагт цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**
Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Хаяг: Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-98, 305 тоот өрөө, утас: 450060 + 243

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ